



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэлийг батлах тухай

Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.20, Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2.6 заалтуудыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь**:

1. “Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.
2. “Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэл”-ийг тодорхойлсон зарчмуудыг авч хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой зохицуулалтын журмыг боловсруулж, батлуулахыг Тусгай зөвшөөрлийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Н.Жигжидсүрэн/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах газрын Зохицуулагчдын зөвлөлийн /хуучин нэрээр/ “Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийг тогтоох тухай” 2004 оны 18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР



Эрчим хүчний зохицуулах хорооны
2014 оны 190 дүгээр тогтоолын хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн этгээдэд эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү баримт бичгийн зорилго оршино.

1.2 Тусгай зөвшөөрлийн зохицуулалттай холбоотой аливаа дүрэм, журам нь энэхүү баримт бичгээр тогтоосон зохицуулалтын бодлого чиглэлд нийцсэн байна.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын асуудлууд

2.1 Эрчим хүчний салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн стратегитай уялдсан байх нь тусгай зөвшөөрлийн зохицуулалтын тулгуур асуудал байна.

2.2 Эрчим хүчний салбарын үр ашгийг сайжруулах, өртөг зардлыг бууруулах, хэрэглэгчийн үйлчилгээг шинэ шатанд гаргах чиглэлд шинэ дэвшилтэт техник, технологи, ухаалаг систем, ухаалаг үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжинэ.

2.3 Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дэмжих төрийн бодлоготой уялдсан зохицуулалтын орчинг бүрдүүлнэ.

2.4 Ногоон эрчим хүч буюу сэргээгдэх эх үүсвэрийг дэмжих чиглэл баримтална.

2.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техникийн найдвартай байдал, үр ашиг, үйлчилгээний төвшинг сайжруулах, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

2.6 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг харилцагч байгууллага, иргэдэд ил тод, нээлттэй, шуурхай болгох чиглэлд мэдээллийн технологийн дэвшилийг нэвтрүүлэх зарчим баримтална.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах суурь зарчмууд

3.1 Тусгай зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг дараах суурь зарчмууд хангагдсан эсэх дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

3.1.1 Эрчим хүчний хангамж, хэрэглээний тэнцэл хангагдсан байх;

3.1.2 Техникийн хувьд найдвартай, аюулгүй, үр ашигтай горим ажиллагааг хангасан байх;

3.1.3 Эдийн засгийн хувьд үр ашигтай, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа зохистой хэмжээнд байх;

3.1.4 Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, цэвэр технологийг хэрэглэх буюу сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ төлөвлөгдсөн байх;

3.1.5 Аливаа хэлбэрийн татаас, санхүүгийн дэмжлэгээр хэрэгжих төслүүдийн хувьд санхүүжилтийн орчин нь тодорхой, баталгаажсан байх;

3.1.6 Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа явуулах техникийн, хүний нөөцийн, санхүүгийн чадавхтай байх;

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн үр нөлөө, үнэлэмж

4.1 Эрчим хүчний салбар тогтвортой, найдвартай, үр ашигтай ажиллах нөхцөл бүрдсэн байх;

4.2 Хэрэглэгчдэд хүрэх үйлчилгээний чанар, стандарт дээшилсэн байх;

4.3 Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бизнес эрх ашгийг хөндөөгүй байх;

4.4 Адил тэгш нөхцөлөөр, шударга өрсөлдөх боломжийг дэмжихэд чиглэгдсэн байх;

Тав. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага

5.1 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагаар тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэхэд хангасан байвал зохих нөхцөл, үйл ажиллагаандаа зайлшгүй мөрдөж ажиллах шаардлагуудыг тогтооно.

5.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техник, эдийн засаг, санхүүгийн үзүүлэлтүүд, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, чанаржуулах бодит механизм болж хэрэгжинэ.

5.3 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг жил бүр дүгнэж, дараагийн жилд мөрдөх нөхцөл, шаардлагын үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтооно.

Зургаа. Тусгайлсан зохицуулалтын чиглэл, зарчим

6.1 Эрчим хүчний хангамж хэрэглээний тэнцэл, түүнчлэн үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн тарифт үзүүлэх нөлөөллийг тооцсоны үндсэн дээр уламжлалт болон сэргээгдэх эх үүсвэрүүдэд Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгох зарчмыг баримтална.

6.2 Цахилгаан дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгоходоо Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авахад тодорхойлсон Техник, эдийн засгийн үзүүлэлтийг хангасан байдлыг гол шалгуур болгон авч үзнэ.

6.3 Цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа эдийн засгийн хувьд үр ашигтай байх нөхцөлийг шалгур болгон жилийн нийт түгээлт 80 сая кВтц-аас их, дулааны нийт чадал 10 Гкал-аас их байх нөхцөлд цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл олгох зарчим баримтална.

6.4 Цахилгаан, дулаанаар зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлийн талаар баримтлах зарчмыг зах зээлийн өрсөлдөөний орчин бий болгох шатанд тусгайлан тодорхойлно.

**Долоо. Зохицуулалтын талаар баримтлах
бодлого, чиглэлд өөрчлөлт оруулах**

7.1 Эрчим хүчний салбарын талаар төрөөс баримтлах бодлого, хөгжлийн чиг, хандлага, зохицуулалтын орчинг шинэчлэх, боловсронгуй болгох зорилгод нийцүүлэн тусгай зөвшөөрлийн зохицуулалтын талаар баримтлах бодлого, чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

7.2 Зохицуулалтын бодлого, чиглэлд оруулах нэмэлт өөрчлөлтийг тухай бүр батлуулна.

7.3 Зохицуулалтын талаар баримтлах бодлого, чиглэлийн хүрээнд дараах журмуудыг мөрдөж ажиллана. Үүнд:

7.3.1 Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах журам

7.3.2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, үнэлэх журам

----- оОо -----



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын
бодлого, чиглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.20, Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.8, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 190 дүгээр тогтоолын 7.2 дах заалтуудыг тус тус үндэслэн, Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын бодлого, чиглэл"-д дор дурдсан агуулгаар нэмэлт оруулан өөрчилсүгэй.

3.1.7-д Тусгай зөвшөөрөл хүсэгчийн санхүүгийн чадавхийг үнэлэхдээ дараах үзүүлэлтүүдэд үндэслэнэ. Үүнд:

- Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл хүсэгч буюу хөрөнгө оруулагчийн зүгээс тухайн төсөлд хөрөнгө оруулах тухай албан ёсны шийдвэр, санхүүжүүлэх төлөвлөгөөний хамт;
- Төслийн нийт хөрөнгийн 10 хувиас доошгүй үнийн дүнг санхүүжүүлэх чадавхийг нотлох, аудитаар баталгаажуулсан хөрөнгө оруулагчийн сүүлийн хоёр жилийн санхүүгийн тайлан тэнцэл;
- Зээл олгогчоос тухайн төсөлд сонирхлоо илэрхийлсэн захидал;

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын алба /Х.Эрдэнэчулуун/-нд даалгасугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР



Тогтоолын тухай